

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

**2006 оны 08 дугаар
сарын 04 -ний өдөр**

Дугаар 29

**Улаанбаатар
хот**

Журам батлах тухай

“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 15.3.5, “Санхүүгийн зохицуулах хорооны эрх үйн байдлын тухай хууль” -ийн 6.1.2, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 34.1.3 дахь заалтуудыг тус тус дэслэн Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ыг хавсралтад дурдсанаар баталсугай.

2. Энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж, нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулахыг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

/Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 192 дугаар тогтоол, 2011 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 116 дугаар тогтоол, 2011 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 208 дугаар тогтоол, 2011 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 245 дугаар тогтоол, 2013 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор орсон өөрчлөлтүүдийг тусгав/

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар Санхүүгийн зохицуулах хорооноос (цаашид “Хороо” гэх) үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (цаашид “тусгай зөвшөөрөл” гэх) олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Хорооноос баталсан энэ журмын дагуу үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19.1-д заасан дараах мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоно. Үүнд:

1.2.1. үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа (хөрөнгийн бирж, дилерүүдийн арилжааны төв);

1.2.2. үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа;

1.2.3. үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа;

1.2.4. хамтын хөрөнгө оруулалтын байгууллага буюу хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа;

1.2.5. брокер, дилерийн үйл ажиллагаа;

1.2.6. андеррайтерийн үйл ажиллагаа;

1.2.7. хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа;

1.2.8. хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа тус тус хамаарна.

1.2.9. Банкны тухай хуулийн 6.2.7-д заасан “харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээ”

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 116 дугаар тогтоолоор нэмсэн/

1.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үнэт цаасны зах зээлд зарим төрлийн үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд зааснаар хавсран эрхлэх эрхтэй. Хавсран эрхлэх үйл ажиллагаанд дараах төрлийн үйл ажиллагаа хамаарна:

1.3.1. хадгаламжийн үйл ажиллагааг төлбөр тооцооны үйл ажиллагаатай;

1.3.2. брокер, дилерийн үйл ажиллагааг хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаатай;

1.3.3. андеррайтерийн үйл ажиллагааг брокер, дилерийн үйл ажиллагаатай;

1.3.4. хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаатай;

1.3.5. андеррайтерийн үйл ажиллагааг харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээтэй.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 116 дугаар тогтоолоор нэмсэн/

1.4. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа нь олгосон өдрөөс хойш 3 жил байна.

1.5. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5.3-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр бусдад шилжүүлж үл болно.

1.6. Үнэт цаасны зах зээлд тусгай зөвшөөрөлгүйгээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

1.7 Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээг эрхлэх этгээд нь энэ журмын 2 дугаар зүйлд заасан шаардлага нөхцлийг хангасан байна.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 116 дугаар тогтоолоор нэмсэн/

1.8. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг дотоод, гадаадын хуулийн этгээд нь өөр улсын үнэт цаасны зах зээлд Монгол улсын иргэдэд хувьцаа худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд Хороонд бүртгүүлнэ. /Хороо шаардлагатай гэж үзвэл нэмэлт баримт, лавлагааг шаардаж болно./

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 39 дүгээр тогтоолоор нэмсэн/

ХОЁР. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ШААРДЛАГА, НӨХЦӨЛҮҮД

2.1. Тусгай зөвшөөрөл хүсч буй хуулийн этгээд нь дараах шаардлага, нөхцөлийг хангасан байна:

2.1.1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд хүрэлцэхүйц хувь нийлүүлсэн болон эргэлтийн хөрөнгөтэй байх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн далаас доошгүй хувийг мөнгөн хөрөнгө, Монголын хөрөнгийн биржийн “А” ангилалд хамаарах үнэт цаасаар бүрдүүлнэ. Үнэт цаас нь эргэлтийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй. Энэ заалт арилжаа эрхлэх болон төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх компанид хамаарахгүй;

/ Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор нэмсэн/

2.1.2. Хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллах;

2.1.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19.2.11-д заасны дагуу харилцагчдын эрэдлээс хамгаалах сан байгуулах; Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19.2.11-д заасны дагуу эргэлтийн хөрөнгийн 3 хувиас доошгүй хувьтай тэнцэх хэмжээгээр эрэдлээс хамгаалах сан байгуулж, тусгай дансанд байршуулах;

/ Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

~~Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19.2.11-дэх заалтад заасны дагуу брокер, дилер, андеррайтерийн компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн 3 хувиас доошгүй хувьтай тэнцэх хэмжээгээр эрэдлээс хамгаалах сан байгуулж, сангийн хөрөнгийг “ҮЦТТХТ” ХХК-ийн тусгайлсан дансанд, ҮЦТТХТ ХХК нь тус сангийн хөрөнгийг эрэгдэл ондөртэй арилжааны банкинд тус тус давхар байршуулах~~

/ Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 245 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19.2.11-д заасны дагуу брокер, дилер, андеррайтерийн компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн 3-аас доошгүй хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгөөр эрэдлээс хамгаалах сан байгуулж, сангийн хөрөнгийг өөрийн тусгайлсан дансанд тогтмол байршуулах.

Эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгийг зөвхөн компани, түүний албан тушаалтнуудын буруутай үйл ажиллагаанаас харилцагчдад учруулсан хохирлыг барагдуулахад зарцуулах бөгөөд уг хохирлыг Хорооны улсын байцаагчийн шалгалтаар тогтоож, захиргааны хэрэгжүүлэх ажиллагаа явуулж албан шаардлагаар барагдуулах үүрэг болгосон байна. Сангийн мөнгөн хөрөнгө энэхүү журамд заасан хэмжээнээс багассан тохиолдолд ажлын 5 хоногийн дотор тогтоосон хэмжээнд нөхөн байршуулна.

/ Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 39 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

- 2.1.4. Мэргэжлийн байгууллагад ажиллах мэргэжилтнүүд нь Хорооноос үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан байх;
- 2.1.5. ~~Дотоод хяналтынүйл ажиллагааг хэрэгжүүлэх хяналтын ажилтантай байх;~~
Дотоод хяналтынүйл ажиллагааг хэрэгжүүлэх орон тооны ажилтантай байх бөгөөд уг ажилтан нь брокер, дилерийн ажлыг хавсран эрхэлдэггүй байх;
/ Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/
Дотоод хяналтынүйл ажиллагааг хэрэгжүүлэх орон тооны ажилтантай байх бөгөөд Хорооноос олгосон мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй гүйцэтгэх захирал, брокер, дилер, үнэлгээ, өсөл, судалгаа, хөрөнгө оруулалтын зөвлөхийн чиглэлийн ажил үүргийг хавсран эрхэлдэггүй байх.
/ Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 39 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/
- 2.1.6. Мэргэжлийн байгууллагад ажиллах ТУЗ-ын дарга, гишүүд болон гүйцэтгэх захирал, захирлын өвлөлийн гишүүд, хяналтын ажилтан нь ял шийтгэлгүй байх;
- 2.1.7. Үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчид, ТУЗ-ын дарга, гишүүд болон гүйцэтгэх захирал бусад боловсон үчин нь сүүлийн 3 жилд зөрчлийн улмаас тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон санхүүгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын гүйцэтгэх удирдлагад ажиллаагүй байх;
- 2.1.8. Харилцагчдыг хүлээн авч үйлчлэх байрыг компанийн брокероос бусад ажиллагсдын алба өрөөнөөс тусгаарласан, үйлчилгээний танхимийн зориулалтаар тохижуулсан байх;
- 2.1.9. Энэ журмын холбогдох хэсгүүдэд заасан ажилтны тоонд тохирсон шаардлага хангахуйц оффисийн тавилга, тоноох ~~хөрөмж~~ /компьютер, принтер, хувилагч, бичлэг хийх боломжтой телефон утас, факсийн аппарат/-өөр хангагдсан байх;
- 2.1.10. Програм хангамж нь тусгай ~~өши~~ өөрлийн дагуу эрхлэх үйл ажиллагааны дотоод журам Хорооноос тогтоосон мэдээллийн сангийн журам, нягтлан бодох бүртгэлийн зааварт заасан шаардлагад нийцсэн, шаардлагатай мэдээллийг гаргах бүрэн боломжтой, тухайн програмын мэдээллийн сангийн хамгаалалт 2-оос доошгүй шаталсан үйлдлээр нэвтрэх шаардлагыг хангасан байх бөгөөд харилцагчтай байгуулсан гэрээ, харилцагчийн үртгэл, тэдний хөрөнгийн хөдөлгөөнтэй холбогдох гүйлгээний мэдээллийг давхар хадгалах боломжтой байх;
- 2.1.11. Мэргэжлийн байгууллагын салбарт брокерийнүүрэг гүйцэтгэх ажилтан нь харилцагчдын өнгөн хөрөнгийг хүлээн авах, дамжуулах үйлчилгээ үзүүлдэггүй, зөвхөн харилцагчдын захиалга, бусад холбогдох баримтыг хүлээн авч бүрдүүлэн түүнийгээ төвдөө дамжуулах, харилцагчдад эргээж мэдэгдэх, харилцагчийн бүртгэл хөтлөх зэрэг ажил эрхэлдэг бол уг брокерийн ажлыг анхан шатны зуучлагчаар дамжуулан гүйцэтгэж болох бөгөөд уг зуучлагч нь Хорооноос зөвшөөрсөн анхан шатны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх шаардлагатай. Хуульд харилхаааргүй бол уг ажилтан нь анхан шатны зуучлалын үйлчилгээг үндсэн ажилтайгаа хавсран эрхэлж болно
- 2.1.12. Мэргэжлийн байгууллагын үндсэн үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэдэг ажилтнууд нь хариуцлагын даатгалд даатгуулсан байх.

/ Энэ хэсгийг Сүх гийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор нэмсэн/

2.1.13. Мэргэжлийн байгууллагын үйцэтгэх захирал, мэргэжилтнүүд давхар ажил, хөдөлмөр эрхэлдэггүй, өөр мэргэжлийн байгууллагын 5 хувь ба түүнээс дээш хувийг эзэмшдэггүй, тэдгээрт эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй байх,
/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 39 дүгээр тогтоолоор нэмсэн/

2.2. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 21, 22, 23-т заасан болон энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах шаардлага, нөхцөлийг хангасан байна:

- 2.2.1. Үнэт цаасны арилжаа эрхлэх нэгжтэй байх;
- 2.2.2. Дотоод мэдээлэл болон нийтэд зориулсан мэдээллийн үйл ажиллагааг хариуцан ажиллах бие даасан нэгжтэй байх;
- 2.2.3. Шинээр гаргаж үнэт цаасыг бүртгэх болон бүртгэлээс хасах үйл ажиллагаа эрхлэх бие даасан нэгжтэй байх;
- 2.2.4. Үнэт цаасны арилжааг хянах бие даасан нэгжтэй байх;
- 2.2.5. *Эргэлтийн хөрөнгө нь нийт хөрөнгийн 30 хувиас багагүй байх, мөн эргэлтийн хөрөнгийн 2 хувьтай тэнцэх хэмжээний эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмыг тогтоосон байх.*
/ Энэ хэсгийг Сүх гийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор нэмсэн/

2.3. Үнэт цаасны төлбөр тооцооны байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24-т заасан болон энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах шаардлага, нөхцөлийг хангасан байна:

- 2.3.1. Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа явуулахад шаардлагатай программ хангамж, техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;
- 2.3.2. Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагааг эрхлэх бие даасан нэгжтэй байх;
- 2.3.3. *Эргэлтийн хөрөнгө нь нийт хөрөнгийн 30 хувиас багагүй байх, мөн эргэлтийн хөрөнгийн 1 хувьтай тэнцэх хэмжээний эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмыг тогтоосон байх.*
/ Энэ хэсгийг Сүх гийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор нэмсэн/

2.4. Үнэт цаасны хадгаламжийн болон үнэт цаасыг өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 25-д заасан болон энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах шаардлага, нөхцөлийг хангасан байна:

- 2.4.1. Үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагааг эрхлэх бие даасан нэгжтэй байх;
- 2.4.2. Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэх бие даасан нэгжтэй байх;
- 2.4.3. Дотоод мэдээлэл эзэмшигчдийн болон байгууллагын дотоод үйл ажиллагааг хянах, харилцагчдаас ирсэн санал гомдлыг шийдвэрлэх 2-оос доошгүй хяналтын ажилтантай байх;
- 2.4.4. *Эргэлтийн хөрөнгө нь нийт хөрөнгийн 30 хувиас багагүй байх, мөн эргэлтийн хөрөнгийн 1 хувьтай тэнцэх хэмжээний эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмыг тогтоосон байх.*
/ Энэ хэсгийг Сүх гийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор нэмсэн/

2.5. Брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27-д заасан болон энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах шаардлага, нөхцөлийг хангасан байна:

- 2.5.1. Брокерийн үйл ажиллагаа эрхлэх ажилтантай байх; *Дилерийн үйл ажиллагаа эрхлэх 2-оос доошгүй ажилтантай байх;*
/ Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/
- 2.5.2. Дилерийн үйл ажиллагаа эрхлэх ажилтантай байх; *Брокерийн үйл ажиллагаа эрхлэх 2-оос доошгүй ажилтантай байх;*
/ Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/
- 2.5.3. Брокер, дилерийн компанийн тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээнд орон нутагт үйлчлэхээр заасан бол тухайн орон нутагт салбараа байгуулж, орон тооны ажилтныг ажиллуулдаг байх.
- 2.5.4. Брокер, дилерийн тусгай зөвшөөрөл шинээр хүссэн хуулийн этгээд нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага/*Хөрөнгийн бирж/* -ийн гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан талаарх тухайн байгууллагын дүгнэлтийг Хороонд ирүүлнэ.
/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 39 дүгээр тогтоолоор нэмсэн/

2.6. Гадаадын хөрөнгө оруулагч дангаараа хувь нийлүүлсэн хөрөнгийг эзэмшдэг мэргэжлийн байгууллагад дараах шаардлага тавигдана. Үүнд:

- 2.6.1. Хуулиар тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байх;
- 2.6.2. Ажиллах боловсон хүчний 70-аас доошгүй хувь нь Монгол улсын иргэдээс бүрдсэн байх;
- 2.6.3. Үйцэтгэх удирдлага нь гадаадын иргэн байгаа нөхцөлд орон тооны мэргэжлийн орчуулагчтай байх.

2.7. Мэргэжлийн байгууллагыг Компанийн тухай хуулийн 13,18 дугаар зүйлд заасны дагуу хувь нийлүүлэх, хувьцаа гаргах, хувьцааны захиалга авах аргаар болон өөрчлөн байгуулах /нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах/ замаар хувьцаат компани (цаашид “ХК” гэх) болон хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид “ХХК” гэх) хэлбэрээр байгуулж болно.

2.8. Мэргэжлийн байгууллагыг ХК хэлбэрээр байгуулах тохиолдолд энэ журмын 3.1-д заасан бичиг баримтуудыг бүрдүүлэн Хороонд ирүүлэх ба Хороо тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсэн тохиолдолд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5-9 дүгээр зүйлийн дагуу үнэт цаасаа Хороонд бүртгүүлж, нийтэд санал болгон арилжаална.

2.9. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд нь уг үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэн эрхлэхийг хүсвэл тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас хуанлийн 30 60 хоногийн өмнө Хороонд тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргана. Өргөдөл гаргахдаа энэ журмын дагуу бичиг баримтаа бүрдүүлж, хавсарган ирүүлнэ.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 208 тоот тогтоолоор өөрчилсөн/

2.10. Тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хариуцан ажилладаг Хорооны хянан шалгагч уг компанийн тусгай зөвшөөрөл дуусахаас 60 хоногийн өмнө газрын даргын албан бичгээр уг тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд энэ тухай мэдэгдэнэ.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 208 тоот тогтоолоор нэмсэн/

2.11. Ийнхүү тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ журмын 4.1-д заасан хугацаанд Хороонд хүсэлтээ ирүүлээгүй тохиолдолд хариуцсан хянан шалгагч тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө хугацаа нь дуусч байгаа болон хүчингүй болсонд тооцох болохыг анхааруулсан мэдэгдэл хүргүүлнэ.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 208 тоот тогтоолоор нэмсэн/

2.12. Тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлөө сунгуулах хүсэлт, холбогдох

баримт бичгээ ирүүлээгүй тохиолдолд Хорооны хянан шалгагч тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан өдрөөс эхлэн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг түр зогсоож, тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцуулахаар Хорооны хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ. /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 208 тоот тогтоолоор нэмсэн/

ГУРАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД ШААРДЛАГАТАЙ БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД

3.1. Тусгай зөвшөөрөл хүссэн этгээд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.4-т зааснаас гадна дараах бичиг баримтуудыг бүрдүүлж Хороонд ирүүлнэ. Үүнд:

- 3.1.1. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг энэ журмын 1 дүгээр хавсралтад заасны дагуу гаргаж ирүүлнэ.
- 3.1.2. Улсын бүртгэлийн албанаас авсан мэргэжлийн байгууллагын оноосон нэрийн зөвшөөрлийн тодорхойлолт.
- 3.1.3. Мэргэжлийн байгууллага байгуулж, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийн эх хувь буюу Нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
- 3.1.4. Тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний Нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
- 3.1.5. Үүсгэн байгуулагчид, хувь нийлүүлэгчдийн гарын үсгээр баталгаажуулсан буюу Нотариатаар гэрчлүүлсэн Компанийн дүрэм. Дүрэмд дараах зүйлийг тусгасан байна:
 - 3.1.5.1. Компанийн тухай хуулийн 16.2-д заасан зүйл;
 - 3.1.5.2. дүрмийн сангийн бүтцэд өөрчлөлт оруулах нөхцөл;
 - 3.1.5.3. хувь нийлүүлэгчдийн хурал хуралдах журам, их хэмжээний хэлцэл хийхэд баримтлах журам, энэ талаарх удирдлагын бүрэн эрх;
 - 3.1.5.4. хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, хянан шалгах зөвлөл, дотоод хяналтын нэгжийн эрх, үүрэг, хариуцлага;
 - 3.1.5.5. мэргэжлийн байгууллагын хувьцаа арилжих, бусдад шилжүүлэх, харилцан хязгаарлалт хийх үйл ажиллагааг зохицуулах хууль зүйн үндэслэл, хууль тогтоомжид заасан бусад асуудал;
 - 3.1.5.6. мэргэжлийн байгууллага татан буундах эслэл, удирдлага, мэргэжилтнүүдийн буруутай үйл ажиллагаанаас иргэд, харилцагчдад учруулсан хохирлыг барагдуулах арга хэлбэр, хариуцлага зарчим.
- 3.1.6. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар болон Хорооноос тогтоосон мэргэжлийн байгууллагын хувь нийлүүлсэн болон эргэлтийн хөрөнгөд хувь нийлүүлэгчдийн оруулсан мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох бичиг баримт, гаралслийн талаарх тодорхойлолт.
- 3.1.7. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээний тухай хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж, үүрэг хүлээсэн байх баталгаа.
- 3.1.8. Мэргэжлийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлсэн мөнгөн хөрөнгө, түүнийг банкинд байршуулсан эсэхийг тодорхойлсон банкны тодорхойлолт, бусад баталгаа.
- 3.1.9. Аудитын байгууллагаар баталгаажуулсан хамгийн үндэсний улирлын санхүүгийн тайлан, шинээр үүсгэн байгуулж байгаа бол эхлэлтийн баланс.
- 3.1.10. Үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчид, ТУЗ-ын дарга, гишүүдийн тухай тодорхойлолт /энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу гаргаж ирүүлэх/.

- 3.1.11. Гүйцэтгэх удирдлага болон бусад боловсон хүчинд Хорооноос олгосон үнэт цаасны зах зээлд ажиллах эрхийн үнэмлэхийн хуулбар, тэдгээрийн тухай тодорхойлолт /энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу гаргаж ирүүлэх/.
- 3.1.12. Мэргэжлийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, гүйцэтгэх удирдлага, мэргэжилтнүүдийн талаарх холбогдох байгууллагаас гаргасан дараах тодорхойлолтууд. Үүнд:
- а/ татварын байгууллагад өр төлбөртэй эсэх талаарх тодорхойлолт;
 - б/ ял шийтгэлтэй эсэх талаарх Цагдаагийн ерөнхий газрын тодорхойлолт;
 - в/ хугацаа хэтэрсэн зээлийг өртэй эсэх талаар Банкны өр барагдуулах алба, зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл;
 - г/ хамгийн сүүлд ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт.
- /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор нэмсэн/*
- 3.1.13. Гадаадын өрөнгө оруулалттай мэргэжлийн байгууллага тухайн орны онцлогоос шалтгаалан энэ журмын 3.1.12-т заасан тодорхойлолтуудыг гаргаж ирүүлэх боломжгүй бол гадаадын хөрөнгө оруулалттай мэргэжлийн байгууллагын үүсгэн байгуулагч нараас энэ тухай баталгаа гаргаж ирүүлнэ.
- 3.1.14. Гадаадын хөрөнгө оруулалттай мэргэжлийн байгууллагын хөрөнгө оруулагч нь гадаадын хуулийн этгээд бол тухайн орныхоо эрхгүй байгууллагад бүртгүүлсэн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар, гадаадын иргэн бол овог нэр, хаяг байршил бүхий бичиг баримт, холбоо барих утас, e-мэйл хаяг. Хороо шаардлагатай гэжүзвэл тухайн орны холбогдох байгууллаг уудаас лавлагаа авах эрхтэй.
- 3.1.15. ХК хэлбэрээр байгуулагдсан хуулийн этгээдийн хувьцааны арилжааны хамгийн сүүлийн тайлан.
- 3.1.16. Техник, тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын байрны тодорхойлолтыг энэ журмын 4үгээр хавсралтын дагуу үйлдэж, түүнд техник тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын байрны найдвартай, үйл аюулг ажиллагаа, нууцлал, харуул хамгаалалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тусгай, дурдсан шаардлагын талаар бусад этгээдтэй байгуулсан гэрээ буюу нотариатын байгууллагаар баталгаажуулсан гэрээний хуулбарыг ирүүлнэ.
- 3.1.17. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх бизнес төлөвлөгөө /Энэ журмын 5 дугаар хавсралтад заасны дагуу гаргаж ирүүлэх/.
- 3.1.18. Мэргэжлийн байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, танилцуулга. Мэргэжлийн үйл ажиллагааг хавсран эрхлэх тохиолдолд үйл ажиллагаа тус бүрийг дотооддоо удирдан зохион байгуулах нэгжийн тухай танилцуулга.
- 3.1.19. Мэргэжлийн байгууллагын хувь нийлүүлэгчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар баталсан Дотоод хяналтын үйл ажиллагааны журмын эх хувь буюу Нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
- 3.1.20. Энэ журмын 3.1.16-д заасан шаардлагыг хангасан эсэхийг дараах байдлаар нотолно:
- 3.1.20.1. Үндсэн үйл ажиллагаанд ашиглах программын танилцуулга, тодорхойлолт. Программ нь Хорооноос тухайн тусгай өвшөөрөлтэй үйл ажиллагаатэй холбогдуулан баталсан журмын шаардлагад хэрхэн нийцэж байгааг танилцуулгад дурдсан байна. Танилцуулгад програмыг өөрөө үүсгэсэн, эсхүл худалдан авсан алин болохыг тодорхойлж худалдан авсан бол*

худалдан авсан гэрээ болон цаашид үзүүлэх үйлчилгээны талаар байгуулсан гэрээний хуулбарыг ирүүлнэ.

*3.1.20.2. Ажлын байр нь компанийн өөрийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний нотариатаар баталгаажсан хуулбар, түрээсийн байр бол түрээсийн гэрээний нотариатаар баталгаажсан хуулбар;
/түрээсийн гэрээг 3-аас доошгүй жилийн хугацаатай байгуулсан байна/.*

*Ажлын байр нь зөвшөөрөл хүсч байгаа үеийн байдлаар БДК байдаггүй аймаг, дүүрэг, хорооны нутаг дэвсгэрт байрлаж байгаа бол давуу тал гэж үзнэ.
/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор нэмсэн/*

3.2. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 21.2.2, энэ журмын 3.1-д зааснаас гадна дараах бичиг баримтуудыг ирүүлнэ:

- 3.2.1. Үнэт цаасыг бүртгэх болон арилжих эрх олгох журам;
- 3.2.2. Үнэт _____ цаасны арилжаа зохион байгуулах журам;
- 3.2.3. Үнэт цаасыг бүртгэх, бүртгэлээс хасах асуудлыг хариуцах бие даасан нэгжийн үйл ажиллагааны тухай журам;
- 3.2.4. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу дотооддоо гаргасан журам, зааврууд;
- 3.2.5. Арилжаа эрхлэх байгууллагын өөслөн удирдах зөвлөл, захирлуудын зөвлөлийн гишүүдийн нэрс, тэдгээрийн эрхэлж буй албан тушаал болон эзэмшиж буй үнэт цаасны талаарх тодорхойлолт;
- 3.2.6. Арилжаа эрхлэх байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлсэн хувь нийлүүлэгчдийн эзэмшиж буй хөрөнгийн хувь хэмжээ. Хувь нийлүүлэгчид, гүйцэтгэх удирдлагуудын хувьд сонирхлын зөрчилтэй хэлцэлд оролцохгүй, сонирхлын зөрчил үүсгэхгүй байх талаарх баталгаа;
- 3.2.7. Үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээний төсөл;
- 3.2.8. Арилжаа эрхлэх байгууллагын гишүүн мэргэжлийн байгууллагуудын нэрс, гишүүн байгууллагатай байгуулах гэрээний төсөл.

3.3. Үнэт цаасны төлбөр тооцооны байгууллага нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

- 3.3.1. Хөрөнгө оруулагчдыг үнэт цаасны төлбөр тооцоотой холбоотой болзошгүй эрсдлээс хамгаалах сан байгуулах, байршуулах ба тухайн сангийн хөрөнгийг захиран зарцуулах нөхцөлийг тусгасан дотоод журам;
- 3.3.2. Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагааны журам;
- 3.3.3. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, хадгаламжийн байгууллагатай хамтран ажиллах гэрээний төсөл;
- 3.3.4. Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэхэд үүсэх эрх, үүргийг тусгасан төлбөр тооцооны үйл ажиллагаанд оролцогч этгээдтэй байгуулах гэрээний төсөл;
- 3.3.5. Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагааг хавсран эрхлэх тохиолдолд төлбөр тооцооны үйл ажиллагааг бие даан эрхлэх дотоод нэгжийн үйл ажиллагааны журам;
- 3.3.6. Үнэт цаасны арилжааны болон арилжааны бус хэлцлийн дүнд үүссэн тооцоог тодорхойлох, төлбөрийг хийж гүйцэтгэх журам, мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам.

/ Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор нэмсэн/

3.4. Үнэт _____ цаасны хадгаламж болон өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

- 3.4.1. Үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагааг эрхлэх нэгжийн чиг үүргийг онцгойлон заасан үйл ажиллагааны журам;
- 3.4.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу дотооддоо мөрдөхөөр гаргасан журам, зааврууд;
- 3.4.3. Харилцагчдын хөрөнгийг эрсдлээс хамгаалах зорилгоор даатгалын байгууллагатай хамтран ажиллах гэрээний төсөл;
- 3.4.4. Харилцагчидтай байгуулах хадгаламжийн гэрээний төсөл;
- 3.4.5. Харилцагч иргэд, байгууллагуудын үнэт цаас худалдсаны болон ногдол ашгийн мөнгөн хөрөнгийг байршуулан хадгалах арилжааны банктай байгуулах гэрээний төсөл;
- 3.4.6. Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх журам. Энэ журамд дараах зүйлүүдийг заавал тусгасан байна:
 - 3.4.6.1. үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл явуулахад үндэслэх бичиг баримт, мэдээлэл;
 - 3.4.6.2. харилцагчийн дансны хуулга, түүний хэлбэр, агуулга, хугацаа;
 - 3.4.6.3. үнэт цаасыг харилцагчийн дансанд бүртгэх, үнэт цаасын өмчлөх эрхийн бүртгэл хийхэд үндэслэсэн баримт бичгийг хадгалах заавар;
 - 3.4.6.4. харилцагчдад зүүлэх үйлчилгээний төрөл, тэдгээрээс авах үйлчилгээний хураамжийн хувь хэмжээ;
 - 3.4.6.5. үнэт цаасны хадгаламж өмчлөх эрхийн бүртгэл, шилжүүлэг, мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам. */Энэ хэсгийг Сангийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор нэмсэн/*
- 3.4.7. Үнэт цаас гаргагч компаниудтай үнэт цаасны бүртгэлийг нь хөтлөх талаар байгуулах гэрээний төсөл;

3.5. Хамтын хөрөнгө оруулалтын байгууллага буюу хөрөнгө оруулалтын сан нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 26.7, Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах тухай журмын 3,4,8 дугаар зүйлүүд энэ журмын 3.1-д зааснаас гадна дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

- 3.5.1. Хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааг хавсран эрхлэх болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааг эрхлэх дотоод нэгжийн үйл ажиллагааны журам;
- 3.5.2. Хөрөнгө оруулалтын сан нь үнэт цаас худалдах, худалдан авах үйл ажиллагааг хөрөнгө оруулалтын менежментийн компаниар дамжуулан хийх бол хамтран ажиллах гэрээний төсөл;
- 3.5.3. Хөрөнгө оруулалтын сангийн хувьцааны үнийг буулгахгүйгээр, харилцагчдын хөрөнгийг зохистой удирдах, сангийн хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлэхэд баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх журам.

3.6. Брокер, дилерийн компани нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

- 3.6.1. Брокерийн болон дилерийн үйл ажиллагаа эрхлэх дотоод журам боловсруулж ирүүлэх ба журамд дараах зүйлийг заавал тусгасан байна:
 - 3.6.1.1. брокерийн болон дилерийн үйл ажиллагаа эрхлэх тухай;
 - 3.6.1.2. дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх тухай;
 - 3.6.1.3. харилцагчдыг эрсдлээс хамгаалах үйл ажиллагааны тухай;
 - 3.6.1.4. харилцагчид, хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх тухай.

3.7. Андеррайтерийн компани нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дараах бичиг баримтыг

бүрдүүлнэ:

- 3.7.1. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх дотоод журам. Журамд андеррайтерийн дараах төрлүүдийн аль хэлбэрээр үнэт цаас гаргагчтай ажиллахыг тодорхой тусгасан байна. Үүнд:
 - 3.7.1.1. Хоёрдогч зах зээлд худалдах бүүрийн үнэт цаасны багцад хадгалах зорилготойгоор анхдагч зах зээлд үнэт цаас гаргагчийн гаргасан үнэт цаасыг бүхэлд нь худалдан авах /"firm commitment"/;
 - 3.7.1.2. Үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлд гаргасан үнэт цаасны зарим хэсгийг худалдан авах /"standby commitment"/;
 - 3.7.1.3. Үнэт цаас гаргагчийн гаргасан үнэт цаасыг худалдан авахгүйгээр дээд зэргийн хүчин чармайлт гарган анхдагч зах зээлд борлуулах үйл ажиллагааг зохион байгуулах /"best effort"/;
 - 3.7.1.4. Үнэт цаас гаргагчийн гаргасан үнэт цаас нь анхдагч зах зээлд арилжигдах боломжгүй нөхцөлд үнэт цаасыг нь тогтоосон үнээр худалдан авах баталгаа гаргах /"bought deal"/.
- 3.7.2. Брокер дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч, Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж 1 жилээс доошгүй хугацаагаар үйл ажиллагаа явуулсан байх;
- 3.7.3. Үйл ажиллагаагаа явуулсан хугацаанд үнэт цаасны тухай хууль тогтоомжийг зөрчөөгүй, харилцагчдад хохирол учруулаагүй талаар арилжаа эрхлэх болон төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагын тодорхойлолт;
- 3.7.4. Үнэлгээ, төсөл, судлагааны 2-оос доошгүй ажилтантай, тэдгээр нь үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх авсан бөгөөд брокер, дилерийг хавсран эрхэлдэггүй;
- 3.7.5. 1 тэрбум төгрөгөөс доошгүй эргэлтийн хөрөнгөтэй компани, мөн 51-ээс дээш хувийн гадаадын өрөнгө оруулалттай бөгөөд өөрийн орны болон гадаад орны үнэт цаасны зах зээл дээр 2 жилээс дээш хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байсан туршилагатай үүсгэн байгуулагчидтай компани андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргавал журмын 3.7.2-3.7.3 дах заалтууд хамаарахгүй.
/ Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор нэмсэн/

3.8. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

- 3.8.1. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх дотоод журам;
- 3.8.2. Хамтран ажиллах хөрөнгө оруулалтын сангуудын нэрс;
- 3.8.3. Хөрөнгө оруулалтын сантай хамтран ажиллах гэрээний төсөл. Гэрээний төсөлд талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхой тусгасан байна.

3.9. Хөрөнгө оруулалтын зөвлөх компани нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

- 3.9.1. Хөрөнгө оруулалтын зөвлөх компани болон үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхөөр ажиллах мэргэжилтний хооронд байгуулах гэрээний төсөл;
- 3.9.2. Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхө өр ажиллах мэргэжилтний баримтлах ёс зүйн дүрэм;
- 3.9.3. Үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх мэргэжилтний олон улсын болон дотоодын зах зээлд ажиллаж мэргэжсэн байдлын тухай танилцуулга;

3.9.4. Мэргэжилтний үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн чиглэлээр гадаадын болон дотоодын сургалтад хамрагдаж мэргэисэн **түгжүүлэх, сертификат, дипломын нотариатаар баталгаажуулсан хуулбар.**

3.10. Гадаадын хөрөнгө оруулалттай мэргэжлийн байгууллага байгуулж, тусгай зөвшөөрөл авахад энэ журмын холбогдох заалтуудад заасан бичиг баримтуудыг монгол хэл дээр 2 хувь үйлдэж ирүүлнэ.

ДӨРӨВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ОЛГОХООС ТАТГАЛЗАХ

4.1. Хороо тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримтуудыг ажлын 21 хоногт хянаж шийдвэрлэнэ.

4.2. Тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримтуудыг бүрэн гүйцэд, үнэн зөв бүрдүүлж Хороонд ирүүлсэн өдрөөс эхлэн шийдвэрлэх хугацааг тооцно.

4.3. Хэрэв бичиг баримтыг зайлшгүй магадлан шинжлэх, нэмж тодруулах шаардлагатай бол нэмэлт материалыг бүрдүүлж ирүүлсэн өдрийг бичиг баримтыг анх хүлээн авсан өдрөөр тооцно.

4.4. Тусгай зөвшөөрөл хүсч буй хуулийн этгээдээс ирүүлсэн бичиг баримтыг дараах тохиолдолд ажлын 10 хоногийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигчид буцаана:

4.4.1. бичиг баримтын бүрдэл дутуу,

4.4.2. тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримт нь холбогдох хуулиуд болон энэ журамд заасан шаардлагуудыг хангаагүй.

4.5. Хороо шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримтын талаар холбогдох газраас тодруулах, магадлан шинжлүүлэх, лавлагаа авах эрхтэй.

4.6. Хороо тусгай зөвшөөрөл хүсч буй хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа явуулахад шаардлагатай орон байр, программ, техник хангамжийн шаардлага хангасан эсэхийг газар дээр нь шалгах эрхтэй. Үнэт цаасны газрын даргын томилсон ажлын хэсэг тусгай зөвшөөрөл хүсч буй этгээдийн үйл ажиллагаа явуулах ажлын байр, тоног төхөөрөмж, программ хангамж нь энэ журмаар тогтоосон шаардлагыг хангасан эсэхийг газар дээр нь шалгаж, дүгнэлт гаргасан байна.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

4.7. Хороо тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримтыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл, энэ журмын холбогдох заалтыг үндэслэн хянаж, шаардлагатай гэж үзвэл газар дээр нь шалгасны үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгох, эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

4.8. Тусгай зөвшөөрөл олгох шийдвэрт тухайн мэргэжлийн байгууллагад үнэт цаасны зах зээлд ямар төрлийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосныг тусгана.

4.9. Энэхүү журмын 4.8-д заасны дагуу гаргасан Хорооны шийдвэр болон тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хэлсийг Хорооны дансанд төвлөрүүлсэн баримтыг үндэслэн тухайн байгууллагад тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгоно.

4.10. Хороо тухайн байгууллагын тусгай зөвшөөрлийг бүртгэн авч, зохих журмын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

4.11. Тусгай зөвшөөрөл хүсч буй байгууллага нь ирүүлсэн бичиг баримтдаа нэмэлт өөрчлөлт оруулсан бол энэ тухайгаа ажлын 15 хоногийн дотор Хороонд мэдэгдэнэ.

4.12. Тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримтууд нь шаардлага хангасан гэж үзээд Хороо тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсний дараа мэргэжлийн байгууллагын хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг Хорооны дансанд байршуулахыг мэргэжлийн байгууллагын үүсгэн байгуулагчид албан бичгээр мэдэгдэнэ.

4.13. Үүсгэн байгуулагч нь уг албан бичгийг хүлээн авснаас хойш хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг ажлын 3 хоногийн дотор холбогдох дансанд төвлөрүүлж, хуанлийн 10 хоног байршуулах ба энэхүү мөнгөн хөрөнгөнд Хороо хүү төлөхгүй.

4.14. Хорооноос тусгай зөвшөөрөл олгогдсон мэргэжлийн байгууллагын гүйцэтгэх удирдлага Хорооны дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг өөрийн харилцах дансанд шилжүүлэх тухай хүсэлтийг албан ёсоор Хороонд тавина.

4.15. Хороо дараах үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана. Үүнд:

4.15.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан болон энэхүү журмаар тогтоосон шаардлагыг хангаагүй;

4.15.2. бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн нь нотлогдсон.

4.16. Тусгай зөвшөөрөл олгохоос Хороо татгалзсан тохиолдолд энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг өргөдөл гаргагчид албан бичгээр хүргүүлнэ.

4.17. Бичиг баримт хуурамчаар үйлдсэн гэдэг үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос Хороо татгалзсан тохиолдолд татгалзсан өдрөөс хойш 1 жилийн дотор уг хуулийн этгээдийн хувь нийлүүлэгчид, гүйцэтгэх удирдлагад ажиллах байсан этгээдүүдээс тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг дахин хүлээж авахгүй.

4.18. Энэ журмын 4.17-д зааснаас бусад үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагуудыг бүрэн хангасан гэж үзсэн хуулийн этгээд тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлөө Хороонд дахин гаргаж болно. Энэ тохиолдолд тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг дахин төлнө.

ТАВ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАВСРАН ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ НЭМЖ ОЛГОХ

5.1. Үнэт цаасны зах зээлд энэхүү журмын 1.3 -т заасан мэргэжлийн үйл ажиллагааг хавсран эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах шалгууруудыг хангасан мэргэжлийн байгууллагад нэмж олгож болно. Үүнд:

5.1.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох журмуудад заасан шаардлагыг бүрэн хангасан;

5.1.2. Хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж, 3 улирлаас дээш хугацаанд үйл ажиллагаагаа хэвийн явуулсан;

5.1.3. тухайн байгууллагын санхүү, төлбөрийн чадвар, нэр хүнд болон хувь нийлүүлэгчдийн бизнесийн ёс зүй, нэр хүнд нь уг үйл ажиллагааг эрхлэхэд харшлахгүй байх.

5.2. Мэргэжлийн үйл ажиллагааг хавсран эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд нэмж эрхлэх үйл ажиллагааг тусгаж, дараах бичиг баримтуудын хамт Хороонд ирүүлнэ. Үүнд:

5.2.1. тухайн үйл ажиллагааг эрхлэх талаарх хувь нийлүүлэгчдийн шийдвэр, нэмж шаардагдах хөрөнгө, зардал, тэдгээрийн эх үүсвэрийн тооцоо;

5.2.2. мэргэжлийн байгууллагын дүрэмд орох өөрчлөлт;

5.2.3. бизнес төлөвлөгөө болон санхүүгийн тайлангуудад орох өөрчлөлтийн төсөл, танилцуулга;

5.2.4. тухайн үйл ажиллагааг эрхлэхэд мөрдөх журам. Энэ журамд хавсран эрхлэх үйл ажиллагааны нэр өөрчлөлт, зохицуулалт, оролцогч талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлага, үйл ажиллагааны эрсдэлийг тооцох аргачлал зэргийг тодорхой тусгасан байна.

5.3. Хороо мэргэжлийн үйл ажиллагаа хавсран эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримтыг хянан шалгаад, энэ нь тухайн байгууллагын санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, харилцагчид нь аливаа хохирол учрахгүй, боловсон хүчний чадавх болон техник,

тоног төхөөрөмж, программ хангамжийн боломж нь тухайн үйл ажиллагааг хэвийн хэмжээнд эрхлэх нөхцөлийг хангаж байна гэж үзвэл уг тусгай зөвшөөрлийг олгох шийдвэр гаргана.

5.4. Мэргэжлийн 0ы1199 .йл ажиллагаа хавсран эрхлэх тусгай зөвшөөрлийн зохицуулалтын хөлсийг Хорооны дансанд төвлөрүүлсэн баримтыг үндэслэн Хороо тухайн мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, баталгаажуулна.

5.5. Тодорхой шалтгаанаар мэргэжлийн үйл ажиллагаа хавсран эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос Хороо татгалзснаас хойш хүсэлт гаргасан мэргэжлийн байгууллага татгалзсан шалтгааныг арилгасан гэж үзээд мэргэжлийн үйл ажиллагаа хавсран эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтээ дахин гаргаж болно.

ЗУРГАА. ДҮРМИЙН САНГИЙН ХЭМЖЭЭ, БҮТЦЭД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, БҮРТГЭХ

6.1. Мэргэжлийн байгууллага нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах асуудлыг дараах хэлбэрээр хийнэ. Үүнд:

6.1.1. үүсгэн байгуулагч болон хувь нийлүүлэгчдээс оруулсан мөнгөн хөрөнгөөр;

6.1.2. хувьцаа нэмж гаргах, шинээр хувь нийлүүлэгч элсүүлэх замаар.

6.2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг тухай бүр Хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авч байна. Зөвшөөрөл авахдаа эдгээр өөрчлөлтийн дагуу аливаа гүйлгээ, төлбөр хийхээс өмнө дараах бичиг баримтуудыг Хороонд ирүүлнэ. Үүнд:

6.2.1. өргөдөл

6.2.2. өөрчлөлт оруулах болсон хууль зүйн үндэслэлийг нотлох бичиг баримт;

6.2.3. мэргэжлийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгөд хувь нийлүүлэн шинээр орж буй хувь нийлүүлэгч (хувь нийлүүлэгчид) -ийн хувьд энэ журмын 3.1.12-т заасан мэдээллийг холбогдох байгууллагаас авсан тодорхойлолт, хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах хөрөнгө нь хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдэж буйг нотлох бичиг баримт;

6.2.4. Мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхийн эсрэг арга хэмжээний тухай хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл, тодорхойлолт;

6.2.5. мэргэжлийн байгууллагын шинэ хувь нийлүүлэгч (хувь нийлүүлэгчид)-ийн талаарх тодорхойлолтыг энэхүү журмын гуравдугаар хавсралтын дагуу гаргах;

6.2.6. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцийг өөрчилсөнтэй холбогдуулан мэргэжлийн байгууллагын дүрэмд орох нэмэлт өөрчлөлт;

6.3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгохыг хүсч мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн хүсэлт, холбогдох бичиг баримтыг Хорооны Ажлын алба Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, энэ журмын холбогдох заалтыг үндэслэн хянаж, шаардлагатай асуудлыг газар дээр нь шалгасны үндсэн дээр санал, дүгнэлт гарган Хорооны даргад танилцуулна. Хорооны дарга холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн мэргэжлийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээнд өөрчлөлт оруулах, эсэх талаар эцсийн шийдвэр гаргана.

6.4. Хувь нийлүүлсэн хөрөнгийг хорогдуулах нь мэргэжлийн байгууллагын санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, бусад хувь нийлүүлэгч, харилцагчдад хохирол учруулахгүй гэж Хороо үзвэл хувь нийлүүлсэн хөрөнгийг хорогдуулах зөвшөөрлийг олгоно.

6.5. Мэргэжлийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахад зөвшөөрөл олгох эсэхийг ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэнэ. Энэ журмын 6.2-д заасан бичиг баримт нь зохих шаардлага хангасан гэж үзвэл хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх мөнгөн хөрөнгийг Хорооны хяналтанд байх дансанд байршуулахыг мэргэжлийн

байгууллагын хувь нийлүүлэгчдэд албан бичгээр мэдэгдэнэ.

6.6. Хувь нийлүүлэгчид нь тус албан бичгийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор мэргэжлийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн мөнгөн хөрөнгийг Хорооны дансанд хуанлийн 10 хоногт байршуулах ба энэхүү мөнгөн хөрөнгөнд Хороо хүү төлөхгүй.

ДОЛОО. МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ОНООСОН НЭРИЙГ ӨӨРЧЛӨХ

7.1. Тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн үйл ажиллагааг хэвийн явуулж, зохистой харьцааны үзүүлэлтүүдийг ханган ажиллаж буй мэргэжлийн байгууллага нь оноосон нэрээ өөрчлөхийг хүсвэл Хороонд өргөдөл гаргах бөгөөд дараах бичиг баримтуудыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

7.1.1. мэргэжлийн байгууллагын оноосон нэрийг өөрчлөх тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр;

7.1.2. улсын бүртгэлийн албанаас авсан шинэ оноосон нэрийн тодорхойлолт;

7.1.3. мэргэжлийн байгууллагын өөрчлөлт оруулсан дүрэм;

7.1.4. бусад шаардлагатай бичиг баримт.

7.2. Хороо мэргэжлийн байгууллагын оноосон нэр солих хүсэлтийг хянаж, оноосон нэрийг өөрчлөх нь мэргэжлийн байгууллагын харилцагчдад сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй гэж үзвэл тухайн мэргэжлийн байгууллагын оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрсөн тухай шийдвэрийг Хорооны дарга гаргана.

7.3. Мэргэжлийн байгууллагын оноосон нэрийг өөрчилсөн тухай Хорооны даргын шийдвэр болон тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хэлсийг Хорооны дансанд төлсөн баримтыг үндэслэн Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, шинээр тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгоно.

НАЙМ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

8.1. Хороо тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.1-д зааснаас гадна дараах үндэслэлээр түдгэлзүүлнэ. Үүнд:

8.1.1. удаа дараа хууль зөрчиж, харилцагчдын эрх ашгийг хохироосон;

8.1.2. Хорооноос тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүдийн шаардлагыг 3 улирал дараалан хангаж ажиллаагүй;

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 39 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

8.1.3. ирүүлбэл зохих санхүүгийн тайлан мэдээг 4 улирал дараалан Хороонд гаргаж өгөөгүй;

8.1.4. мэргэжлийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгө нь хуулиар тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээнд хүрээгүй нь шалгалтаар илэрч, улсын байцаагчийн актаар тогтоогдсон;

8.1.5. Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний жилийн хөлс төлөх хугацааг 3-аас дээш сараар хэтрүүлсэн;

8.1.6. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл;

8.1.7. энэ журмын 4.13, 6.6-д заасны дагуу үрмийн сангийн мөнгөн хөрөнгийг Хорооны дансанд байршуулаагүй.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор нэмсэн/

8.2. Хороо Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1-т заасан

болон дараах үндэслэлээр мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.
Үүнд:

- 8.2.1. мэргэжлийн байгууллага дампуурсан буюу төлбөрийн чадваргүй болсон буюу татан бугддсан тухай эрх бүхий байгууллага болох шүүх, мэргэжлийн байгууллагын хувь нийлүүлэгчдийн хурлаас зарласан;
- 8.2.2. мэргэжлийн байгууллага байгуулахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш илэрсэн;
- 8.2.3. мэргэжлийн байгууллага нь улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 1 жилээс дээш хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй;
- 8.2.4. Хорооноос баталж гаргасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн шаардлагыг 6 улирал дараалан хангаж ажиллаагүй;
- 8.2.5. ирүүлбэл зохих санхүүгийн тайлан мэдээг 6 улирал дараалан Хороонд гаргаж өгөөгүй;
- 8.2.6. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй;
- 8.2.7. энэ журмын 8.1-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлснээс хойш түдгэлзүүлсэн шалтгааныг арилгаагүйгээр тухайн үйл ажиллагааг үргэлжлүүлэн эрхэлсэн буюу 6 сарын хугацаанд түдгэлзүүлсэн тухай шийдвэрийг цуцлах нөхцөл бүрдээгүй;
- 8.2.8. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.
- 8.2.9. Харилцагчдад хохирол учруулсан нь хууль хяналтын байгууллагын шалгалт, шийдвэрээр тогтоогдсон.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 39 дүгээр тогтоолоор нэмсэн/

8.3. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчин төгөлдөр бус гэж үзнэ:

- 8.3.1. тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан;
- 8.3.2. тусгай зөвшөөрөл эзэмшигч нь татан буугдсан, үйл ажиллагаагаа зогсоосон, өөрчлөн байгуулагдсан.

8.4. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд:

- 8.4.1. тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, “ХҮЧИНГҮЙ” тэмдэг дарж тухайн байгууллагын хувийн хэрэгт хавсарган, холбогдох журмын дагуу архивт шилжүүлнэ;
- 8.4.2. тусгай зөвшөөрөл дахин олгохтой холбоотой хүсэлтийг тухайн байгууллагаас 1 жилийн дотор дахин хүлээн авахгүй.

8.5. Энэ журмын 8.1-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлснээс хойш түдгэлзүүлсэн шалтгааныг арилгаагүйгээр тухайн үйл ажиллагааг үргэлжлүүлэн эрхэлсэн, буюу 6 сарын хугацаанд түдгэлзүүлсэн тухай шийдвэрийг цуцлах нөхцөл бүрдээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

8.6. Хороо үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхээр олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд энэ тухай олон нийтэд мэдээлнэ.

8.7. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд түдгэлзүүлсэн үндэслэл болсон зөрчил дутагдлыг арилгаж, хэвийн үйл ажиллагааг хангасан гэж үзвэл тухайн байгууллага тусгай зөвшөөрлөө сэргээлгэх хүсэлтийг Хороонд гаргаж болно. Хорооноос түдгэлзүүлсэн шалтгааныг арилгасан гэж үзвэл тусгай зөвшөөрлийг сэргээнэ. Хэрэв хүсэлт гаргаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

ЕС. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН БОЛОН ХҮЧИНГҮЙ БОЛГОСНООС ҮҮСЭХ ҮР ДАГАВАР

9.1. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосноос тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний харилцагчдад учирсан хохирлыг мэргэжлийн байгууллага хариуцна.

9.2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш мэргэжлийн байгууллага нь түдгэлзүүлсэн нөхцөл, шалтгааныг арилгахаас бусад дараах үйлдэл хийхийг хориглоно. Үүнд:

9.2.1. шинээр гэрээ байгуулах;

9.2.2. тухайн өдрөөс өмнө байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах.

9.3. Тусгай зөвшөөрөл хүчингүй болсон тохиолдолд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

9.3.1. Брокер дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан компанийн тусгай зөвшөөрөл хүчингүй болсон тохиолдолд дараах бичиг баримтыг архивын журмын дагуу нэгж болгон цэгцэлж, хавтаслан өөрийн харъяалах арилжаа эрхлэх байгууллагын архивт хүлээлгэн өгнө.

9.3.1.1. үйл ажиллагаа явуулсан бүхий л хугацаанд харилцагчдаас хүлээн авсан үнэт цаас худалдах, худалдан авах захиалгын гэрээнүүд;

9.3.1.2. мөн хугацааны бүх захиалгын бүртгэлүүд;

9.3.1.3. мөн хугацааны бүх дилерийн даалгаварууд;

9.3.1.4. мөн хугацааны харилцагчдийн бүх бүртгэлүүд;

9.3.1.5. мөн хугацаанд харилцагчдад мөнгө олгосон бүртгэл, мөнгөн хөрөнгийн баримтууд, түүний дотор мөнгө хүссэн өргөдлүүд;

9.3.1.6. харилцагчийн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой бусад үндсэн баримтууд;

9.3.1.7. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай Хорооны шийдвэрт заасан бусад баримтууд.

9.4. Брокер дилерийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай Хорооны шийдвэрт ямар бичиг баримтыг ямар хугацаанд хаана хүлээлгэн өгөх талаар тодорхой заана.

9.5. Энэ журмын 9.3 болон Хорооны шийдвэрт заасан баримт бичигийг зохих журмын дагуу хүлээлгэн өгөөгүйн улмаас харилцагчдад учруулсан хохирлыг тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан компанийн хувь нийлүүлэгч, хэрэв тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ХК бол тухайн үеийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан этгээдүүд хамтран хариуцаж барагдуулна.

/ Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор нэмсэн/

АРАВ. МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ ТОМИЛОХ, ӨӨРЧЛӨХ

10.1. Мэргэжлийн байгууллагын гүйцэтгэх захирлыг томилохдоо Хорооноос зөвшөөрөл авна.

10.2. Хорооноос зөвшөөрөл авахдаа дор дурьдсан бичиг баримтыг бүрдүүлж ирүүлнэ:

10.2.1. Гүйцэтгэх захирлаар томилох этгээдийн товч намтар, анкет,

10.2.2. Төгссөн сургуулийн дипломын нотариатаар баталгаажсан хуулбар;

10.2.3. Өмнө ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт, ажлаас чөлөөлөгдсөн тухай шийдвэрийн хуулбар;

10.2.4. Үнэт цаасны зах зээлд ажиллах эрхийн үнэмлэхийн хуулбар;

10.2.5. Гүйцэтгэх захирлаар томилохоор санал болгож байгаа хувь нийлүүлэгчээс ирүүлсэн танилцуулга, үндэслэл.

10.3. Гүйцэтгэх захирлыг өөрчилж байгаа бол тэр тухай шийдвэрийн хуулбар, өөрчлөх болсон шалтгааны талаар мэргэжлийн байгууллагын тайлбар.

10.4. Гүйцэтгэх захирлаар томилохоор санал болгож байгаа этгээд нь үнэт цаасны захзээлийн мэргэжлийн байгууллагыг удирдах мэдлэг боловсрол, дадлага туршилага, ёс зүйн хувьд дараахь шаардлагыг хангасан гэж үзвэл Хороо уг этгээдийг томилох зөвшөөрөл олгоно:

10.4.1. Дээд боловсролтой;

10.4.2. 1 жилээс доошгүй хугацааны удирдах ажлын туршилагатай;

10.4.3. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх авсан;

10.4.4. Өмнө нь үнэт цаасны зах зээл дээр ажиллаж байсан бол үнэт цаасны хууль тогтоомж зөрчсөний улмаас арга хэмжээ авагдаж байгаагүй, эсхүл ийнхүү зөрчсөний улмаас тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон мэргэжлийн байгууллагад эрх бүхий албан тушаал эрхэлж байгаагүй.

10.5. Гүйцэтгэх захирлаар томилохоор санал болгож байгаа этгээд нь энэ журмын 10.4-т заасан шаардлагыг хангаагүй гэж Хороо үзээд зөвшөөрөл өгөхөөс татгалзвал тухайн компани гүйцэтгэх захирлыг томилох зөвшөөрөл авахаар өөр этгээдийн нэрийг 1 сарын дотор санал болгоно.

АРВАН НЭГ. МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

11.1. Мэргэжлийн байгууллага нь салбартай байж болно.

11.2. Мэргэжлийн байгууллагын салбар нээх зөвшөөрлийг Хорооны даргын шийдвэрээр олгоно.

11.3. Мэргэжлийн байгууллагын салбар нь зөвхөн тухайн байгууллагын оноосон нэрийг хэрэглэх бөгөөд салбарын эрхлэх үйл ажиллагааны чиглэл, хүрээ, ажиллах журмыг мэргэжлийн байгууллагын ТУЗ, байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал тогтооно.

11.4. Салбар байгуулах мэргэжлийн байгууллага дараах шаардлагыг хангасан байна:

11.5.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг бүрэн хангасан;

11.5.2. 12 сараас дээш хугацаагаар Хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж, үйл ажиллагаагаа хэвийн явуулсан.

11.6. Мэргэжлийн байгууллага нь салбар нээх зөвшөөрөл хүсэхдээ дараахь баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ:

11.6.1. Салбар нээх тухай хүсэлт;

11.6.2. Тухайн салбарын үйл ажиллагаа явуулах чиглэл, хүрээг тодорхойлсон баримт бичиг, тухайн салбарынүжб эрсдлийг мэргэжлийн байгууллага хариуцах талаар хувь нийлүүлэгчдийн хурлаас гаргасан шийдвэр;

11.6.3. Салбарын удирдлага, брокерийн тодорхойлолтыг энэ журмын 3 дугаар хавсралтаар гаргаж, Хорооноос олгосон эрхийн үнэмлэх, гэрчилгээ, иргэний үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар, үүнэжурмын 2.3.14-т заасан болонөр төлбөртэй эсэх талаарх эрх бүхий байгууллагын /татвар, гааль, өр барагдуулах алба/ тодорхойлолтууд;

11.6.4. Салбарын дотоод хяналтыг хэрэгжүүлэх болон салбарын үйл ажиллагааг зохицуулах журам;

11.6.5. Салбарын үйл ажиллагаа явуулах ажлын байр, үйл ажиллагаандаа ашиглах тоног төхөөрөмж, компьютерийн техникийн үзүүлэлт, ашиглах программ хангамж;

11.6.6. Хорооноос шаардсан бусад баримт бичиг.

11.7. Хороо энэ журмын 6.6-д заасны дагуу ирүүлсэн баримт бичгийг хянан үзээж, салбар

байгуулах нь тухайн хуулийн этгээдийн санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, үйлчлүүлэгчдэд хохирол учруулахгүй, боловсон хүчин, тоног төхөөрөмж, программ хангамж нь тухайн салбарын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг хангасан гэж үзвэл зөвшөөрөл олгоно.

11.8. Мэргэжлийн байгууллага нь салбараа нээх, татан буулгах, үйл ажиллагааг хязгаарлах, өөрчлөн байгуулах /нэгтгэх, нийлүүлэх, салгах, тусгаарлах, өөрчлөх/, байршилгүйг нь өөрчлөх, /хооронд нь солих, шилжүүлэх/ тухай бүрд шийдвэр гаргаж, уг шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор Хороонд ирүүлж, бүртгүүлнэ.

11.9. Мэргэжлийн байгууллагын салбар нээх тухай Хорооны даргын шийдвэр, Хорооноос баталсан тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоох тухай журамд зааснаар зохих хураамжийг Хорооны дансанд төлсөн баримтыг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтанд салбарын талаарх тэмдэглэлийг хийж баталгаажуулна.

11.10. Хороо тухайн байгууллагын салбар санхүүгийн хүндрэлд орсон, холбогдох хууль тогтоомжид нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй буюу тухайн салбарын санхүүгийн байдал мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл салбарын үйл ажиллагааг зогсоож болно.

11.11. Мэргэжлийн байгууллагын салбарын зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд ажлын 5 хоногийн дотор энэ тухай тэмдэглэл хийнэ:

11.11.1. Салбар татан буулгах талаар гарсан тухайн мэргэжлийн байгууллагын удирдлагын шийдвэр;

11.11.2. Тухайн салбарын үйл ажиллагаа нь мэргэжлийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварт хүндрэл учруулахаар байгааг тогтоосон Хорооны улсын байцаагчийн дүгнэлт;

11.11.3. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

11.11.4. Хорооноос тухайн компанид салбар нээн ажиллуулахыг зөвшөөрсөнөөс хойш 3 сарын хугацаанд тухайн орон нутагт салбар нь үйл ажиллагаа явуулаагүй, мөн түүнчлэн салбарын үйл ажиллагааг явуулж байгаад 3 сараас дээш хугацаагаар зогсоосон.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 39 дүгээр тогтоолоор нэмсэн/

11.12. Мэргэжлийн байгууллагын хувь нийлүүлэгчдээс салбарын үйл ажиллагааг зогсоох үндэслэл болсон зөрчлийг арилгаж, зохих шаардлагыг хангасны дараа салбар нээх хүсэлтийг дахин хүлээж авах бөгөөд зохицуулалтын үйлчилгээний хөлсийг хүсэлт гаргах бүрдээ холбогдох журамд заасан хэмжээгээр заавал төлнө.

11.13. гадаад улсад салбар байгуулах тохиолдолд дээрх шаардлагаас гадна нэмэлт нөхцлийг Хорооноос тавьж болно.

/Энэ зүйлийг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор нэмсэн/

11.14. Орон нутагт үртгэлтэй эсхүл тухайн орон нутагтаа үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага нь Улаанбаатар хотод салбар нээх тохиолдолд журмын 2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 39 дүгээр тогтоолоор нэмсэн/

АРАВ. АРВАН ХОЁР. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

12.1. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тухай Хорооны шийдвэр гарснаас хойш уг үйл ажиллагааг үргэлжлүүлэн эрхэлбэл тусгай зөвшөөрөлгүйгээр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэж Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

12.2. Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавьж холбогдох хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 18.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38.1-д заасан хариуцлага хүлээлгэнэ.

/ Энэ зүйлийг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 192 дугаар тогтоолоор өөрчлөн дугаарласан/

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ**

Огноо :
Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,
Засгийн газрын IV байр
Бага тойруу -6
Улаанбаатар -210646
Монгол улс.

Хэнээс:
.....
.....

(*өргөдөл гаргагчийн овог, нэр, хаяг, утас, факс, электрон шуудангийн хаяг*)
.....
/мэргэжлийн байгууллагын нэр/ */ХК, ХХК/*

Мэргэжлийн байгууллагын үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/ шинээр мэргэжлийн байгууллага үүсгэн байгуулах зорилгоор хурал хийж, үнэт цаасны зах зээлд дор дурдсан мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхээр шийдвэрлэсэн болно. Үүнд:

- 1/
 - 2/
- /мэргэжлийн үйл ажиллагааны төрөл/*

Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд дараах хуулийн этгээд, хуулийн этгээдийг үүсгэн байгуулагч иргэд тус мэргэжлийн байгууллагад хөрөнгө оруулахаар шийдвэрлэв.

№	Овог нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар/Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар/	Хаяг	Хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээ/мянган, төгрөгөөр/

Мэргэжлийн байгууллагын үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/ нь өөрийн хууль ёсны өмчлөлд байгаа хөрөнгөөр хувь нийлүүлсэн болно.

Мэргэжлийн байгууллагын гүйцэтгэх удирдлагад /гүйцэтгэх захирал, нэгжийн удирдлага, ерөнхий нягтлан бодогч, дотоод хяналтын ажилтнууд/ дараах хүмүүс ажиллах болно. Үүнд:

№	Овог нэр	Одоогийн эрхэлж байгаа ажил	Регистрийн дугаар	Мэргэжлийн байгууллагад эрхлэх албан тушаал

Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар бүрдүүлж хүргүүлсэн баримт материалуудыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн бичиг баримтад аливаа худал ташаа зүйл орсон хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох бичиг баримтыг хянан шалгаж, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоно уу.

Бид үйл ажиллагаандаа “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль” болон холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн биелүүлж байх болно.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

/...../
/гарын үсэг/

/...../
/овог, нэр /

Хуулийн этгээд бол:

/тамга тэмдэг/

.....
/хуулийн этгээдийн нэр/

.....
/албан тушаал /

/...../
/гарын үсэг/

/...../
/овог, нэр/

МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮССГЭН БАЙГУУЛАГЧ, ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИД БОЛОН ТУЗ-ЫН ДАРГА, ГИШҮҮДИЙН ТОДОРХОЙЛОЛТ

А. Мэргэжлийн байгууллагатай ямар холбоотой болохыг тэмдэглэнэ үү.

1. Үүсгэн байгуулагч
2. Нийт хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн
дарга
гишүүн

Б. Үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/-ийн талаар

1. Үүсгэн байгуулагч нь:

Хуулийн этгээд Иргэн

2. Мэргэжлийн байгууллагад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ:

Энгийн хувьцаа

Давуу эрхтэй хувьцаа

..... / / төгрөг

/тоогоор/ /үсгээр/

3. Үүсгэн байгуулагч /хувь нийлүүлэгч/ нь хуулийн этгээд бол дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ. Үүнд:

- Оноосон нэр:
- Байгуулагдсан он, сар, өдөр:
- Үйл ажиллагаа эрхлэх хугацаа:
- Байршил буюу хаяг:
- Улсын бүртгэлийн дугаар:
- Регистрийн дугаар:
- ТУЗ-ын дарга, гишүүдийн овог нэр:
- Регистрийн дугаар:
- Хувь нийлүүлэгчдийн овог нэр:
- Регистрийн дугаар:
- Эрхэлж буй үйл ажиллагааны төрөл:
- Хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбогдсон танилцуулга

/эрхэлж ирсэн үйл ажиллагааг хугацаагаар нь, хараат буюу охин компанитай буюу нэгжтэй эсэх, тэдгээрийн болон тухайн байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн үр дүн,


байриил, өмчлөлийн байдал, бусад байгууллагад хувь нийлүүлсэн хөрөнгө зэргийг хамруулан бичнэ/.

- Хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлсэн хөрөнгийн танилцуулга, тодорхойлолт.

Хуулийн этгээдийн нэр нь мэргэжлийн байгууллагын хувь нийлүүлэгч болж тус мэргэжлийн байгууллагын дүрмийн санд оруулж байгаа / үсгээр / төгрөг нь манай хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдэж байгаа бөгөөд холбогдох материалуудыг үнэн зөвөөр хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн танайд хүргүүлсэн болохоо нотлохын зэрэгцээ үүнээс үүсэх аливаа эрсдлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн хариуцахаа илэрхийлж байна.

4. Үүсгэн байгуулагч нь иргэн бол дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ:

- Овог, нэр:
- Төрсөн он, сар, өдөр:
- Иргэний харьяалал:
- Гэрийн хаяг:
- Иргэний үнэмлэхийн дугаар:
- Регистрийн дугаар:
- Эрхэлж байгаа ажил:
 - хугацаа:
 - хаяг:



- Боловсролын талаар /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

Д/д	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

- Ажлын туршлагын талаар

Д/д	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

5. Хувь нийлүүлэгчийн нэгдмэл сонирхолтой этгээдийн байдал:

Д/Д	Таны юу болох	Овог нэр	Регистрийн дугаар	Эрхэлж буй албан тушаал

.....овогтой миний бие мэргэжлийн байгууллагын хувь нийлүүлэгч болж тус мэргэжлийн байгууллагын дүрмийн санд оруулж байгаа / үсгээр / төгрөг нь миний хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдэж байгаа бөгөөд холбогдох материалуудыг үнэн зөвөөр хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн танайд хүргүүлсэн болохоо нотлохын зэрэгцээ үүнээс үүсэх аливаа эрсдлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн хариуцахаа илэрхийлж байна.

Нэгдмэл сонирхолтой этгээдийн товч танилцуулгад урьд өмнө эрхэлж байсан ажил төрлийн байдал, аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, бусдад өр, зээлтэй эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ.

..... Мэргэжлийн байгууллагыг төлөөлж
/албан тушаал/

/...../
/гарын үсэг/

/...../
/овог, нэр/

МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, НЭГЖИЙН УДИРДЛАГА БОЛОН БУСАД БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

1. Мэргэжлийн байгууллагын гүйцэтгэх захирал, нэгжийн удирдлага бусад боловсон хүчин нь дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ:

- овог, нэр:
- эрхлэх албан тушаал:
- төрсөн он, сар, өдөр:
- иргэний харьяалал:
- гэрийн хаяг:
- утасны дугаар:
- иргэний үнэмлэхийн дугаар:
- регистрийн дугаар:
- одоо эрхэлж байгаа ажил:
 - хугацаа:
 - хаяг:
- Боловсролын талаар */Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/*

Д/д	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

- Ажлын туршлагын талаар

Д/д	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

• гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний товч танилцуулга (аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллагуудтай харьцаж байсан түүх, харилцагч банкууд, өөр аль нэг хуулийн этгээдийн хувь нийлүүлэгч эсэх, бусдад өр, зээлтэй эсэх одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ):

3. Гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний холбогдох этгээдийн байдал:

Нэгдмэл сонирхолтой этгээд гэдгийг Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд

тодорхойлсноор ойлгоно.

Д/Д	Таны юу болох	Овог нэр	Регистрийн дугаар	Эрхэлж буй албан тушаал

Нэгдмэл сонирхолтой этгээдийн товч танилцуулгад урьд өмнө эрхэлж байсан ажил, төрлийн байдал, аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, бусдад өр, зээлтэй эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ.

Гүйцэтгэх удирдлага боловсон хүчний талаарх хууль хяналт, татвар, банк болон бусад холбогдох хуулийн этгээд, байгууллага, иргэдээс гаргуулан авсан тодорхойлолт, лавлагаа зэргийг хавсаргав.

..... мэргэжлийн байгууллагыг төлөөлж

/албан тушаал/

*/...../
/гарын үсэг/*

*/...../
/овог, нэр/*

ПРОГРАММ ХАНГАМЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглах техник, тоног төхөөрөмжийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Д/д	Техник, тоног төхөөрөмжийн төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан, түрээслэсэн аль нь болох	Тоо ширхэг

Мэргэжлийн байгууллага нь дээрх тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, компьютерээс гадна үнэт цаасны арилжааны, төлбөр тооцооны, хадгаламжийн болон бусад. (программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ, зээлийн мэдээллийн санд мэдээ өгч, авах зориулалт бүхий (программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ, болон –Г. (худалдан авсан, худалдан авах гэж байгаа буюу гэрээ хийсэн байгаа аль нь эсэхийг бичих) бөгөөд өдөр тутмын мэдээ, мэдээлэл боловсруулалтын ажилд компьютерийн (программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ ашиглах болно.

Мэргэжлийн байгууллага нь үйл ажиллагаа явуулах байрыг:

худалдан авсан

түрээслэсэн

бөгөөд энэхүү байр нь мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэхэд тохиромжтой, аюулгүй байдлын хувьд бүрэн хамгаалагдсан болно.

Ажлын байрны шаардлага болон харуул хамгаалалтын найдвартай байдлыг хангасан гэж үзэж дор дурдсан бичиг баримтуудыг хавсаргав.

Худалдан авсан байрны үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ

Түрээслэсэн байрны түрээсийн гэрээ

Харуул хамгаалалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тайлбар

..... мэргэжлийн байгууллагыг төлөөлж /албан тушаал/

/...../ /гарын үсэг/

/...../ /овог, нэр/

МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

1. Бизнес төлөвлөгөө гэдэг нь мэргэжлийн байгууллагын зорилго, зорилтуудыг тодорхойлж, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэхэд түүний бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний шуурхай, найдвартай ажиллагаа, удирдлагын ур чадвар, санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлт, үр ашгийг жил тутам сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой цаг хугацаагаар төлөвлөн боловсруулсан баримтыг хэлнэ.

2. Мэргэжлийн байгууллага нь бизнес төлөвлөгөөг өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан боловсруулах бөгөөд дараах зүйлүүдийг заавал тусгасан байна. Үүнд:

- 2.1. үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зорилго, баримтлах бодлого, мэргэжлийн байгууллагын хэтийн төлөв байдал;
- 2.2. үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд ашигтай байх макро болон микро түвшин дэхь боломжит нөхцөлүүд;
- 2.3. мэргэжлийн байгууллагын тайлан тэнцэл, мөнгөн хөрөнгийн урсгал, орлого зарлагын 3-5 жилийн төсөөлөл;
- 2.4. актив, пассивын бүтэц, хэмжээ түүний удирдлагыг сайжруулах төлөвлөгөө, хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлүүд, энэ талаар баримтлах бодлого;
- 2.5. үйл ажиллагаатай холбогдон гарах эрсдлийг тодорхойлж, түүнийг удирдахад авах арга хэмжээ.

3. Бизнес төлөвлөгөөг үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэн явуулж эхэлснээс хойш 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн боловсруулна.

4. Бизнес төлөвлөгөө нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

Нүүр хуудас

Бизнес төлөвлөгөөний нүүр хуудсанд дараах зүйлсийг тусган харуулна:

- Мэргэжлийн байгууллагын нэр, хаяг
- Бизнес төлөвлөгөөний нэр
- Хувилбарын дугаар
- Боловсруулсан огноо
- Зохиогчийн нэр, хаяг
- Зохиогчийн тэмдэглэл
- Мэргэжлийн байгууллагын удирдлагын нэр, хаяг

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

Энэ бүлэгт тухайн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллагын тухай, хэрэгжүүлэх гэж буй бизнес төлөвлөгөөний эрхэм зорилго, зорилт, амжилтын үндэс, учирч болох эрсдэл болон санхүүгийн бусад үзүүлэлтүүдийн тухай товч мэдээллийг багтаана.

Эрхэм зорилго гэдэг нь хэний ямар хэрэгцээг, яаж хангах тухай тодорхойлолт юм.

Зорилт гэдэг нь эрхэм зорилтонд хүрэхийн тулд шат дараалан хэрэгжүүлэх, хугацаатай, хэмжигдэхүйц бодитой үр дүн буюу хүрэх цэг юм.

2. БИЗНЕСИЙН ТАНИЛЦУУЛГА

Бизнесийн танилцуулга гэдэг нь тухайн мэргэжлийн байгууллагын нэр, хаяг, өсөж

хөгжиж ирсэн түүх, хариуцлагын тогтолцоо, зах зээлийн нөхцөл төлөв байдал, эрхэлж байгаа үйл ажиллагаа, гаргаж буй үйлчилгээ түүнчлэн удирдлага боловсон хүчний хангалт, санхүүгийн чадавхи ба байдал бизнес төлөвлөвлөгөө бичих болсон шалтгаан, зорилго зорилтууд түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр, зээлийг эргэж төлөх хугацаа, үр ашиг, борлуулалтын орлого, ашиг зэргийг тусган харуулсан хураангуй тодорхойлолт юм.

Бизнесийн танилцуулга нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ:

- Бизнес ба түүний түүх
- Зах зээлийн нөхцөл төлөв байдал
- Одоо явуулж байгаа үйл ажиллагаа
- Удирдлага боловсон, хүчин
- Санхүүгийн байдал төлөв
- Бизнес төлөвлөгөө бичих болсон шалтгаан, зорилго

3.МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бизнес төлөвлөгөөний “маркетингийн төлөвлөгөө”-г дараах гурван хэсгийг багтаана.

3.1. Зах зээлийн шинжилгээ

Маркетингийн төлөвлөгөөг боловсруулахын тулд юуны түүрүүнд зах зээл буюу хэрэглэгчдийнхээ тухай судалж мэдэх, зах зээлийг тань булаацалдах өрсөлдөгчид, танайд бараа үйлчилгээ үзүүлэх түншүүд, зуучлагчдынхаа талаар судлах ёстой.

3.2. Маркетингийн стратеги

Маркетингийн стратеги гэдэг нь зах зээл рүү хандсан төлөвлөгөө буюу амжилт олохын тулд танай байгууллагын хэрэглэж буй арга замууд юм.

3.3. Маркетингийн иж бүрдэл

Танай байгууллага зах зээл рүүгээ хандах арга зам буюу стратегиа тодорхойлсон бол одоо зах зээл дээр таатай байдал үүсгэхийн тулд байгууллагын ашигладаг хүчин зүйлс буюу маркетингийн иж бүрдлийг хэрхэн бүрдүүлэх вэ? Маркетингийн иж бүрдэлд үйлчилгээ, үнэ, идэвхжүүлэлт, хуваарилалтын талаар тусгана.

4. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бизнес төлөвлөгөөний энэ бүлэгт удирдлага, зохион байгуулалт, боловсон хүчний хэрэгцээ гэсэн асуудлуудыг багтааж оруулна.

Удирдах баг: Бизнес төлөвлөгөөний энэ хэсэгт удирдах багийн гишүүд нь банк санхүү, менежментийн чиглэлээр хэр мэргэшсэн, бие биенээ орлох чадвар нь ямархуу болох, мэргэжил дадлага туршлагатай байх шаардлагыг хэр зэрэг хангасан байдал болон эрх мэдэл, ажил үүргийг оновчтой хуваарилсан байдал зэргийг харуулах хэрэгтэй. Удирдах багийн болон мэргэжилтэн (хуулийн зөвлөх г.м.), тэргүүлэх ажилтны (салбаруудын удирдлага г.м.) дадлага, туршлага, тухайн салбарт ажилласан байдал, үүрэг хариуцлага зэрэг тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдээлэл бүхий намтрыг бизнес төлөвлөгөөндөө хавсаргах шаардлагатай. Түүнчлэн удирдах багийн гишүүн бүрийн эрх үүрэг хариуцлагыг нягт тогтоож, хэн нь хэнд захирагддаг, хэн эцсийн шийдвэр гаргадгийг зааж байгууллагын дүрэмд оруулан баталгаажуулж, төлөвлөгөөндөө хавсаргаж болно.

Зохион байгуулалтын бүтэц: Удирдах багийн дор зохион байгуулалтын шат дамжлага багатай, хамгийн үр ашигтай бүтцийг тогтоох нь чухал. Цөөн хүнтэй хамт олны зохион байгуулалтын бүтцийн үр ашигтай байх үндэс зарчим нь нэг удирдлагатай байх, ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдагч мэдээллээр сайн хангагддаг байх, ажиллагчид

ажлынхаа үр дүнг сонирхдог байх, хяналт ил тод байх явдал болно. Энэхүү зарчмыг баримтлан зохион байгуулалтын бүтцээ тогтоож бизнес төлөвлөгөөндөө оруулна.

Боловсон хүчин: Энэ хэсэгт шаардлагатай мэргэжлийн боловсон хүчин тэдгээрийн тоо түүнчлэн мэргэжил эзэмшүүлэх эсвэл мэргэжил дээшлүүлэх сургалтын асуудлуудыг төлөвлөх болно.

Энэ хэсэгт нийт ажиллагчид болон шаардлагатай мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээ, уг ажлыг гүйцэтгэх ажиллагсдын тоо түүнчлэн нийт ажиллагсдын сар, жилийн цалингийн хэмжээ, цалингийн шимтгэлийг тооцоолж төлөвлөнө.

Сургалтанд зориулсан зардал хэдийгээр гаднаас нь харахад ашиггүй мэт боловч үр ашгаа зүй ёсоор өгдөг гэдгийг анхаарвал зохистой.

5. САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Санхүүгийн төлөвлөгөөнд дараах хэсгүүд орно. Үүнд :

- Нийт орлогын тооцоо;
- Үйл ажиллагааны урсгал зардлын тооцоо;
- Ашиг/ алдагдлын тооцоо;
- Алдагдалгүй ажиллагааны тооцоо;
- Мөнгөн урсгалын тооцоо орно.

6. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

6.1. Эрсдэлийн төрлүүд:

Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд 4 төрлийн үндсэн эрсдэлийг тооцоолно. Үүнд:

- Техник, тоног төхөөрөмжийн
- Санхүүгийн буюу зээлийн
- Хүний хүчин зүйлийн
- Хууль зүйн

6.2. Эрсдэлийг багасгах боломжууд

Эдгээр эрсдэлээс чухам ямар нь танай бизнест тохиолдож болох магадлал илүү вэ?

Түүнийг доод хэмжээнд байлгахын тулд та ямар арга хэмжээ төлөвлөснөө бичих нь зүйтэй. Дараа нь даатгалд хамруулж болох эрсдэлийг ангилж ямар нөхцлөөр аль даатгалын компанитай гэрээ хийхээ тодорхойлж бичнэ. Харин даатгалд үл хамаарах эрсдэлийн талаар авах арга хэмжээг хэрхэн төлөвлөж байгааг тодорхойлох шаардлагатай.

Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсны дүнд мэргэжлийн байгууллагын ашигт ажиллагаа хэрхэн хадгалагдаж үлдэхийг төлөвлөсөн үр дүнтэй жишиж харьцуулна.